

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.08.18

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Инфляцын түвшийн 7-р сард 8.1% гарлаа.
- Ирэх улиралд зээлийн хүү өсөх хүлээлт илүү давамгайлж байна.
- Энэ оны эхний хагас жилд ТОП-20 компанийн орлого нэмэгдсэн ч ашиг буурлаа.
- Дотоодын хөрөнгө оруулалтын багцад: Голомт, Хаан, ХХБ, Төрийн банк, МХБ, Инновэйшн Инвестмент багтаж байна.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.1%	-0.71%	-4.7%
MSE A	-0.91%	-1.21%	20.27%
MSE B	-0.72%	-0.21%	34.89%

2025/08/11 – 2025/08/15

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	419,657,399.00
INV	329,877,685.00
XAC	261,833,532.59
MGLA	152,819,855.00
MSE	110,315,205.35

2025/08/11 – 2025/08/15

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
DZG	180.00	14.92%
ADL	470.00	9.30%
UID	3,630.00	8.36%
GOV	265.00	8.16%
KHAN	1,179.00	5.08%

2025/08/11 – 2025/08/15

2025 он 08-р сарын 18

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,269

ТОП-20 индекс

49,004

MSE A

18,179

MSE B

14,372

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

2.4%

2024 - I улирал

Инфляц

8.1%

2025-07 сар

ГВУН(сая\$)

5,379.75

2025-07 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT


3,593.62

2025-08-17

Эдийн засгийн мэдээлэл

ИНФЛЯЦЫН ТҮВШИН 7-Р САРД 8.1% ГАРЛАА

График 1. Үнийн өсөлт, %




2025 оны 7-р сарын байдлаар хэрэглээний барааны бүлгийн үнэ 5.4%-иар өссөн бол үйлчилгээний бүлгийн үнэ 16.6%-иар өсжээ. Хамгийн өндөр үнийн өсөлтийг орон сууц, ус, цахилгаан, түлштэй холбоотой зардлууд бүрдүүлж байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ

График 2. Инфляцын хүлээлт



Ирэх улирлын өрхийн зардал, хуримтлалын хүлээлт өмнөх улирлын түвшинтэй адил өрхийн санхүүгийн тэнцэл, хуримтлал бага зэрэг буурах хүлээлттэй байна. Ажил эрхлэлт буурах төлөвтэй гэсэн хүлээлт давамгайлж байна. Мөн иргэдийн хувьд эдийн засаг удаашрах, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах хүлээлттэй гарлаа. Ирэх улиралд зээлийн хүү өсөх хүлээлт илүү давамгайлж байна.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШИГ БУУРАВ



График 3. Орлогын өсөлт
(өнгөрсөн оны мөн үеэс)

График 4. Цэвэр ашгийн өсөлт
(өнгөрсөн оны мөн үеэс)

*Тэрбум төгрөгөөр


2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангууд гарч дууссан бөгөөд ТОП-20 индекст багтах компаниудын нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 10 гаруй хувиар өсч 5,471.4 тэрбум төгрөгт хүрлээ. Гэсэн ч цэвэр ашгийн хэмжээ 18.3 хувиар буурч 1,064.2 тэрбум гараад байна.

Үүнд бодлогын хүү 10-аас 12% болтол өссөн үзүүлэлт болон төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс ₮3,420-3,590 болсон нь голлон нөлөө үзүүлээ гэж таамаглаж байна.



ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТИЙН БОЛОМЖТОЙ ХУВЬЦААНУУД

График 5. P/E болон P/B харьцаа хамгийн багтай компаниуд




ТОП-20 индекст багтах компаниудын үнэлгээний үзүүлэлтүүдийг тооцож P/E болон P/B харьцаа хамгийн багтай компаниудыг шүүж гаргаж ирлээ. Дотоодын хувьцааны багцад дараах хувьцаанууд 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр тохиромжтойд үнэлэгдэж байна: Голомт, Хаан, ХХБ, Төрийн банк, МХБ, Инновэйшн Инвестмент

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.